



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2019.03.25 № 111  
ганай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

БҮРД СУМЫН ТӨСВИЙН  
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ, СУМЫН  
ЗАСАГ ДАРГА Г.БАЯРМӨНХ-д

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Бүрд сумын Төрийн сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Бүрд сумын Төрийн сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бүрд сумын Төрийн сангийн 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлан-хугацааны санхүүгийн тайлан, тод болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, з үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтэ стандарт болон Аудитын олон улсын стандартыг хүлээн зөвшөөрсөн зарчим төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайланд санал дагуу аудит хийж жилийн эцсийн үгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага мөргөж.

ДАРГА БӨГӨӨД  
ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР *С. Лам Сун* ЛЛАМААЧИН



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бүрд сумын Төрийн сан 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ӨВА-2019/16/СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

()

2019 он

Тэргүүлэх аудитор: Л.Ламаачин

Утас: 70323253 Цахим хаяг: Lamaachinl@yahoo.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: Gansukh\_au@yahoo.com

Ахлах аудитор: Ж.Нямаа

Утас: 70323108 Цахим хаяг: Nyamaa\_au@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                 |

## Агуулга

|         |   |    |
|---------|---|----|
| 1       | Аудитын тайлан .....  | 3  |
| 1.1.    | Оршил .....   | 3  |
| 1.2.    | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....   | 3  |
| 1.3.    | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....  | 3  |
| 1.4.    | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....  | 4  |
| 1.5.    | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... | 5  |
| 1.6.    | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....   | 5  |
| 1.7.    | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....  | 6  |
| 1.8.    | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....   | 6  |
| 1.8.1   | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар .....     | 6  |
| 1.8.2   | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар .....              | 7  |
| 1.8.2.1 | Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....                                   | 8  |
| 1.9.    | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....                                  | 8  |
| 1.10.   | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....   | 8  |
| 1.11.   | Шилэн дансны мэдээлэл .....   | 9  |
| 1.12.   | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....  | 9  |
| 1.13.   | Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл: .....  | 10 |
| 1.14    | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....   | 10 |

## 1 Аудитын тайлан

### 1.1. Оршил

Бүрд сумын Төрийн сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Засаг дарга Г.Баярмөнхөд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 1.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Бүрд сумын Төрийн сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүрд сумын Төрийн сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 12-ноос 2019 оны 03 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын ахдах аудитор Ж.Нямаа хариуцаж хэрэгжүүлэв.

Бүрд сумын Төрийн сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 1/36 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 1.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБООС, АООС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНБООС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

#### 1.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Бүрд сумын Төрийн сангийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Бүрд сумын Төрийн сан нь Тухайн шатны төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

- Нутгийн өөрөө удирдах байгууллын үйл ажиллагаа
- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага
- Сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа
- Ерөнхий боловсролын үйл ажиллагаа
- Соёл урлагын үйл ажиллагаа
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ

Бүрд сумын Төрийн сангийн удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНБООС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

СС-ын 73-р тушаалд өөрчлөлт орсон.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 9 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 8 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Бүрд сумын Төрийн сангийн эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

| № | Байгууллагын ангилал  | Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр |             |                |                     |                      |
|---|-----------------------|---|-------------|----------------|---------------------|----------------------|
|   |                       | Санал дүгнэлт гаргасан                    | Түүвэрлэсэн | Итгэл үзүүлсэн | Гэрээгээр хийлгэсэн | Аудитад хамрагдаагүй |
| 1 | ТТЗ                   | 1   |             |                |                     |                      |
| 1 | Төсвийн шууд захирагч | 4   | 3           | 1              | 1                   |                      |
| 2 | ТБӨААН                |   |             |                |                     |                      |
|   | Дүн                   | 5   | 3           | 1              | 1                   |                      |

Тайлбар: СХТ-ийн 2018 оны санхүүгийн тайланд "Дөлгөөн хайрхан" ХХК гэрээгээр аудит хийж бие даасан дүгнэлт гаргасан нь санал дүгнэлт гаргасан тоонд давхар орсон.

#### 1.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Бүрд сумын Төрийн сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Бүрд сумын Төрийн сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Бүрд сумын Төрийн сангийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Э-тайлан"-гийн програм хангамж ашигладаг байна.

Бүрд сумын Төрийн сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Бүрд сумын Төрийн сангийн дотоод аудитын алба 6 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийжээ. Аудитаар илэрсэн зөрчлийг хэрэгжүүлж ажилласан.

#### 1.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Бүрд сумын Төрийн сангийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.



Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг 5301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

#### **1.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Төлөвлөлтийн үе шатанд тооцсон суурь өөрчлөгдөөгүйтэй холбоотой юм.

Бүрд сумын Төрийн сангийн 2018 оны Нийт зардлын 1 хувь болох 25,843.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

#### **1.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорилыг төсвийн талаар, хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Бүрд сумын Төрийн сангийн болон төвлөрүүлэн захирагчын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 18468.2 мянга, төсвийн төвлөрүүлэн захирагчын хэмжээнд 150676.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 156070.5 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангилалаар үзүүлэв. Үүнд:

##### **1.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар**

Асуудал 1: Бүрд сумын ЗДТГ-т Аймгийн ИТХ-ын 2017 оны 06/08 тогтоол, аймгийн Засаг даргын 2018. А/210 тоот захирамжаар компьютер тоног төхөөрөмж худалдан авахаар хуваарилсан боловч ЗДТГ-ын барилгад урсгал засварт зарцуулсан

- Асуудал 2: ЕБС-д хүүхдийн хоолны материалын нийт шаардахын дүнг, тайланд тусгасан зардлын дүнтэй тулгаж үзэхэд 2043.9 мянган төгрөгийн материал илүү зарлагдсан байна.
- Асуудал 3: СХТ-д хэрэгжүүлсэн горим сорилоор 1 хүнтэй холбоотой урьд оны 1390.1 мянган төгрөгийн, тайлант онд 3 хүнд олгосон цалингийн урьдчилгаанаас 239.9 мянган төгрөгийг онд нь багтаан барагдуулаагүй зэрэг материаллаг хэмжээний залруулагдаагүй алдаа зөрчил илэрчээ.

Шийдэл: Дээрх илэрсэн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

**1.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 1 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Үүнээс: Залруулгын ангилал

| № | Залруулгын товч утга  | Мөнгөн дүн (мянган төгрөгөөр) | Үүнээс: Залруулгын ангилал                              |  |  |   |
|---|---|-------------------------------|---|--|--|---|
|   |   |                               | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой | Тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа | Өмнөх тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа | Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлттэй холбоотой |
| 1 | ЭМТ-д газрыг үнэлж бүртгэхдээ дансны харьцаа буруу хийгдсэн.                              | 76974.5                       |   | 76974.5  |  |   |
| 2 | Цэцэрлэгийн дахин үнэлгээний эхний үлдэгдэл өмчийн өөрчлөлтийн тайланд буруу нэгтгэгдсэн. | 73701.8                       |   | 73701.8  |  |   |
|   | Дүн   | 150676.3                      |   | 150676.3   |  |   |

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

**Бүрд сумн Төрийн сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

| № | Шийдэл  | Тоо | Дүн  | Тайлбар |
|---|---|-----|------|---------|
| 1 | Зөвлөмж өгсөн                                   | 0   | 0.00 |         |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон                         | 0   | 0.00 |         |
| 3 | Албан шаардлага өгсөн                           | 0   | 0.00 |         |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн        | 0   | 0.00 |         |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0   | 0.00 |         |
|   | Дүн   | 0   | 0.00 |         |

**• 1.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.

**1.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 12 сарын 01-ны 06/08 тоот, сумын ИТХ-ын 2017 оны 12 сарын 18-ны 4/03 тоот тогтоолоор суманд олгох санхүүгийн дэмжлэгийг 258950.1 мянган төгрөг, аймгийн ОНХСангаас сумын ОНХСанд олгох орлогын шилжүүлгийг 71160.4 мянган төгрөгөөр баталсан.

Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 12 сарын 01-ны 06/08 тоот тогтоол, сумын ИТХ-ын 2017 оны 12 сарын 18-ны 4/03 тоот тогтоолоор СӨБ 146001.3 мянган төгрөг, ЕБС 617211.7 мянган төгрөг, Соёлын үйлчилгээ 88134.4 мянган төгрөг, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний зардалд 292873.1 мянган төгрөг, нийт 1144220.5 мянган төгрөгийн зардал баталсан. Гүйцэтгэлээр СӨБ 148001.3, ЕБС 600156.4, СХТ 94962.6, ЭМТ 291393.1 мянган төгрөгийн, нийт 1134513.4 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож батлагдсан төсвөөс 9707.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Сумын ИТХ-ын 2017 оны 12 сарын 18-ны 4/02 тоот тогтоолоор сумын татварын орлогыг 64710.2, татварын бус орлогыг 6523.6, нийт 71233.8 мянган төгрөгийн татварын болон татварын бус орлого оруулахаар баталсан. Гүйцэтгэлээр татварын орлогоор 119221.6, татварын бус орлогоор 13614.2, нийт 132835.8 мянган төгрөгийн орлого орж 186.5 хувь буюу 61602.0 мянган төгрөгөөр давж биелэсэн байна. Үүнд: ан амьтаны нөөц ашигласны төлбөр 51200.0 мянган төгрөгийн орлого орсон нь нөлөөлсөн.

Сумын ИТХ-ын 2017 оны 12 сарын 18-ны 4/02 тоот тогтоолоор ИТХ-д 55240.8 мянган төгрөг, ЗДТГ-т 276943.1 мянган төгрөгийн төсөв зарцуулах эрх олгогдсон байна. Сумын ЗДТГ-

**Бүрд сумн Төрийн сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

ын өөрийн орлогыг 2000.0 мянган төгрөгөөр, СХС-ийн үндсэн үйл ажиллагааны зардлыг 200000.0 мянган төгрөгөөр тус тус баталсан бол сумын ИТХ-ын 2018 оны 10 дугаар сарын 04-ны 7/01-ны тогтоолоор урьд оны үлдэгдлээр төсөвт тодотгол хийж ИТХ-ын төсвийг 949.3 мянган төгрөгөөр, ЗДТГ-ын төсвийг 993.4 мянган төгрөгөөр, СХС-ийн санхүүжилтийг 6566.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна. Гүйцэтгэлээр бүрэн санхүүжигдсэн байна.

Сумын ИТХ-ын 2017 оны 12 сарын 18-ны 4/02 тоот тогтоолоор сумын ОНХСангаас хийгдэх хөрөнгө оруулалт барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг 71160.4 мянган төгрөгөөр баталж санхүүжилт бүрэн орсон.

Бүрд сумын төрийн сангийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 1747566.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж 1533664.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоор 84956.1 мянган төгрөг оруулж, 1650949.1 мянган төгрөгийг зарцуулж, 2193.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн орлого, зардлын төлөвлөгөөний биелэлтийг харьяа байгууллагаар нь авч үзвэл

**Мянган төгрөгөөр**

| д/д | Байгууллагын нэр | Батлагдсан төсөв | Гүйцэтгэл | Хувь |
|-----|------------------|------------------|-----------|------|
| 1   | ИТХ              | 56190.2          | 56095.6   | 99.8 |
| 2   | ЗДТГ             | 277936.5         | 276053.4  | 99.3 |
| 3   | ЕБС              | 600656.4         | 600537.9  | 99.9 |
| 4   | Цэцэрлэг         | 148001.3         | 148001.3  | 100  |
| 5   | СХТ              | 95662.6          | 95645.6   | 99.9 |
| 6   | Эмнэлэг          | 291393.1         | 291393.1  | 100  |
| 7   | ОНХС             | 71160.4          | 52349.0   | 73.5 |
| 8   | СХС              | 206566.0         | 130873.0  | 63.3 |
|     | Дүн              | 1747566.5        | 1650949.1 | 94.5 |

**1.11. Шилэн дансны мэдээлэл**

Бүрд сумын Төрийн сан Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

**1.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Бүрд сумын СХТ, Цэцэрлэг, ЭМТ, ИТХ зэрэг төсвийн байгууллагуудад өмнөх онд 4 зөвлөмж, СХТ, ЭМТ-д 8.8 сая төгрөгийн албан шаардлага хүргэгдэж 2018 оны 11, 06 дугаар саруудад албан тоотоор хариу ирүүлсэн байна.

Бүрд сумн Төрийн сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эдгээр зөвлөмж, албан шаардлагийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

**1.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Бүрд сумын Төрийн сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 93.1 хувь буюу 82368.7 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 6.4 хувь буюу 5674.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 0.5 хувь буюу 400.0 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

(Мянган төгрөг)

| № | Байгууллагын ангилал | Илрүүлэлт |        |       |          |          |          | Залруулга |          |
|---|----------------------|-----------|--------|-------|----------|----------|----------|-----------|----------|
|   |                      | Зөрчил    |        | Алдаа |          | Бүгд дүн |          | Тоо       | Дүн      |
|   |                      | Тоо       | Дүн    | Тоо   | Дүн      | Тоо      | Дүн      |           |          |
| 1 | ТТЗ                  |           |        | 2     | 150676.3 | 2        | 150676.3 | 2         | 150676.3 |
| 2 | ТШЗ                  | 3         | 5674.0 | 5     | 5794.2   | 8        | 11468.2  | 3         | 5394.2   |
|   | Дүн                  | 3         | 5674.0 | 7     | 156470.5 | 10       | 162144.5 | 5         | 156070.5 |

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

| № | Байгууллагын ангилал | Залруулаагүй алдаа, зөрчил |        | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |        | Зөвлөмж |       | Хариуцлага тооцуулах санал |     | Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|---|----------------------|----------------------------|--------|---------------|-----|-----------------|--------|---------|-------|----------------------------|-----|--|-----|
|   |                      | Тоо                        | Дүн    | Тоо           | Дүн | Тоо             | Дүн    | Тоо     | Дүн   | Тоо                        | Дүн | Тоо  | Дүн |
|   |                      |                            |        |               |     |                 |        |         |       |                            |     |  |     |
| 1 | ТТЗ                  |                            |        |               |     |                 |        |         |       |                            |     |  |     |
| 2 | ТШЗ                  | 5                          | 6074.0 |               |     | 3               | 5674.0 | 2       | 400.0 |                            |     |  |     |
|   | Дүн                  | 5                          | 6074.0 |               |     | 3               | 5674.0 | 2       | 400.0 |                            |     |  |     |

**1.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Бүрд сумын Төрийн сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бүрд сумын Төрийн сангийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайланд тусаднь хавсаргав.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Бүрд сумн Төрийн сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)

| № | Байгууллагын ангилал | Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор) |                |       | Дүн |
|---|----------------------|-----------------------------------|----------------|-------|-----|
|   |                      | Зөрчилгүй                         | Хязгаарлалттай | Сөрөг |     |
| 1 | ТТЗ                  | 1                                 |                |       | 1   |
| 1 | ТШЗ                  | 4                                 |                |       | 4   |
| 2 | ТБОВААН              |                                   |                |       |     |
|   | Дүн                  | 5                                 |                |       | 5   |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *[Signature]* Л.ЛАМААЧИН

АУДИТЫН МЕНЕЖЕР *[Signature]* Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН

АХЛАХ АУДИТОР *[Signature]* Ж.НЯМАА

2019 ОНЫ 03 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР

Бүрд сумын зөрчлийн нэгтгэл

Тайлант огноо: 2018-12-31

| Дд  | Байгууллагын нэр            | Алдаа, зөрчлийн утга   | Нийт алдаа      |                 | Нийт зөрчил  |            | Нийт алдаа зөрчил |                   | Материллаг      |                 | Дүнлэл          |                |              |
|---|-----------------------------|--|-----------------|-----------------|--------------|------------|-------------------|-------------------|-----------------|-----------------|-----------------|----------------|--------------|
|   |                             |  | Нийт дүн        | Заглуулсан      | Нийт дүн     | Акт        | Албан шаардлага   | Нийт алдаа зөрчил | Заглуулсан сан  | Материллаг      |                 | Материллаг бус |              |
| <b>Бие даасан дүгнэлт гаргасан байгууллагууд</b>            |                             |  |                 |                 |              |            |                   |                   |                 |                 |                 |                |              |
| 1   |                             | ЗДТ- т урсгал засвар хийсэн боловч калитгалжуулан бүртгэсэн.   | 2900.0          | 2900.0          | 0            |            | 2900.0            |                   | 2900.0          |                 |                 |                |              |
| 2   | Бүрд ЗДТ/бие даасан дүгнэлт | Аймгийн Засаг даргын 2018 оны АЗ14 тоот захирамаар ХХААГ-аас шилжүүлсэн 26642.8 мянган төгрөгийн анны үнэгэй 2470.2 мянган төгрөгийн хуримтлагдсан элдэглэлтэй тазврийн хэрэгслийг орлого авахдаа үндэх төгрөгөөр орлого авсан нь баланст, үр дүгийн тайлан тайлант жилийн элэгдэл зөрүтэй тайлагнагдсан | 2470.2          | 2470.2          | 0            |            | 2470.2            |                   | 2470.2          |                 | Зөрчилгүй       |                |              |
| 3   |                             | Аймгийн ИТХ-ын 2017 оны 06/08 тогтоол, аймгийн Засаг даргын 2018. АЗ10 тоот захирамаар компьютер тоног төхөөрөмж худалдан авахаар хуваарилсан боловч ЗДТ-ын барилгад урсгал засвар зарцуулсан  | 0.0             |                 | 2000.0       |            | 2000.0            |                   | 2000.0          |                 |                 |                |              |
| 4   | Бүрд ЭМТ-ов                 | Горми сорилт хэрэгжүүлэхэд 0.4 сая төгрөгийн шатажрууныг эд хариулагч тайланд тусгажгүй.   | 400.0           |                 | 400.0        | 1          | 0.0               |                   | 400.0           |                 | 400             |                |              |
| 5   | Бүрд сумын ЕБС              | Хүүхдийн хоолны материалын нийт шаардахын дүнг, тайлац тусгасан зардлын дүнтэй тулгаж үзэхэд, 2043970 төгрөгийн материал илүү зарлагдсан байна   | 0               |                 | 2044.0       |            | 2044.0            |                   | 2044.0          |                 | Зөрчилгүй       |                |              |
| 6   | СХТ                         | Харгалжусан горим сорилгоор 1 хүнтэй холбоотой урьд оны 1390.1 мянган төгрөгийн, тайлант онд 3 хүнд олгосон цалингийн урьдчиланаас 239.9 мянган төгрөгийг онд нь багтаан барагдуулаагүй  | 0               |                 | 1630.0       |            | 1630.0            |                   | 1630.0          |                 | Зөрчилгүй       |                |              |
| <b>Бие даасан дүгнэлт гаргасан байгууллагуудын нийт дүн</b> |                             |  | <b>5770.2</b>   | <b>5370.2</b>   | <b>400.0</b> | <b>1</b>   | <b>400.0</b>      | <b>5674.0</b>     | <b>0.0</b>      | <b>5674.0</b>   | <b>5370.2</b>   | <b>5674.0</b>  | <b>400.0</b> |
| <b>Түүвэрт хамрагдсан байгууллагууд</b>                     |                             |  |                 |                 |              |            |                   |                   |                 |                 |                 |                |              |
| 7   | Бүрд сумын ИТХ ОНХС         | ХХОАТ-ийн өвлөлийг бүртгэлд тусгаагүй  | 24.0            | 24.0            | 0            |            | 24.0              |                   | 24.0            |                 |                 |                |              |
| 8   | СХС-ан                      | Зээл авсан газрын гэрчилгээг үлсын бүртгэлд бүртгүүлээгүй  | 0.0             |                 | 0.0          | 1          | 0.0               |                   | 0.0             |                 |                 |                |              |
| <b>Түүвэр хийсэн байгууллагуудын нийт дүн</b>               |                             |  | <b>24.0</b>     | <b>24.0</b>     | <b>0.0</b>   | <b>1</b>   | <b>0.0</b>        | <b>0.0</b>        | <b>0.0</b>      | <b>24.0</b>     | <b>0.0</b>      | <b>0.0</b>     |              |
| 9   | Төрийн сан                  | ЭМТ-д газрыг үнэлж бүртгэхэд дансны хэрцүүд буюу хийгдсэн. Цэцэрлэгийн дэхин үндэглэлийг эхлэм үлдэгдэл өмчийн өөрчлөлийн тайланд буюу нэгтгэгдсэн   | 76974.5         | 76974.5         |              |            |                   |                   | 76974.5         |                 |                 |                |              |
| 10  |                             | ТТЗ-ын дүн   | 73701.8         | 73701.8         | 0            |            | 73701.8           |                   | 73701.8         |                 |                 |                |              |
| <b>Сумын нийт дүн</b>                                       |                             |  | <b>150676.3</b> | <b>150676.3</b> | <b>0.0</b>   | <b>0.0</b> | <b>0.0</b>        | <b>0.0</b>        | <b>150676.3</b> | <b>150676.3</b> | <b>0.0</b>      | <b>0.0</b>     |              |
| <b>Хувь хэмжээ</b>  |                             |  | <b>156470.5</b> | <b>156070.5</b> | <b>400.0</b> | <b>2.0</b> | <b>5674.0</b>     | <b>0.0</b>        | <b>5674.0</b>   | <b>156070.5</b> | <b>156070.5</b> | <b>5674.0</b>  | <b>400.0</b> |
|   |                             |  |                 | <b>96.3</b>     | <b>0.2</b>   |            | <b>3.5</b>        | <b>100</b>        |                 |                 |                 |                |              |

Бэлтгэсэн/Ахлах зүрхлөр

Асан шатанд төлсөн/Аудитын мөхөөр

Хөр дэм шатанд төлсөн/Дарга, гэрүүлж ауйлор

Ж.Ньмаа

Д.Гансүх

Л.Баянжиг

Огноо:

Огноо:

Огноо:




## АУДИТЛАГДСАН САНХУУГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл       | Эцсийн үлдэгдэл      |
|------------|---|----------------------|----------------------|
| 1          | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b>525330483.85</b>  | <b>617888986.91</b>  |
| 31         | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>   |                      |                      |
| 312        | Банкинд байгаа бэлэн мөнгө  | 90911559.46          | 118284439.13         |
| 3121       | Төгрөг  | 90911559.46          | 118284439.13         |
| 31211      | Төрийн сангийн харилцах   | 90911559.46          | 118284439.13         |
| 33         | <b>АВЛАГА</b>   |                      |                      |
| 33100      | Ажиллагчидтай холбогдсон авлага                                       | 1390085.00           | 2157654.00           |
| 33400      | Зээлийн хүүгийн авлага  | 4730630.00           | 7986570.00           |
| 33402      | Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/                                       | 26432.76             | 769889.00            |
| 335        | <b>Бусад авлага</b>   | <b>265527737.60</b>  | <b>301672724.50</b>  |
| 3351       | Байгууллагаас авах авлага   | 18223993.10          | 24150000.00          |
| 3352       | Хувь хүмүүсээс авах авлага  | 247303744.50         | 277522724.50         |
| 35         | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | <b>162744039.03</b>  | <b>187017710.28</b>  |
| 351        | <b>Түүхий эд материал</b>   | <b>7152807.43</b>    | <b>8850957.68</b>    |
| 35110      | Тусгай зориулалттай материал  | 3240514.25           | 3696414.25           |
| 35130      | Эм боох материал  | 3912293.18           | 5154543.43           |
| 354        | <b>Хангамжийн материал</b>  | <b>155591231.60</b>  | <b>178166752.60</b>  |
| 35410      | Бичиг хэргийн материал  | 488500.00            | 730211.00            |
| 35420      | Аж ахуйн материал   | 135371720.60         | 154015828.60         |
| 35460      | Хүнсний материал  | 19731011.00          | 23420713.00          |
| 2          | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b>3265395207.40</b> | <b>6783179411.00</b> |
| 39         | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | <b>3265395207.40</b> | <b>6783179411.00</b> |
| 392        | <b>Биет хөрөнгө</b>   | <b>3264452707.28</b> | <b>6711840838.80</b> |
| 39201      | Барилга, байгууламж, орон сууц  | 3070682657.00        | 5704074416.59        |
| 39202      | Хуримтлагдсан элэгдэл   | -1038422763.48       | -17682620.19         |
| 39203      | Авто-тээврийн хэрэгсэл  | 254291772.00         | 272667129.15         |
| 39204      | Хуримтлагдсан элэгдэл   | -118857342.80        | -151485259.34        |
| 39205      | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 1205634731.70        | 1281851356.70        |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл   | -497109041.94        | -606350519.40        |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 136571210.92         | 140794610.92         |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл   | -78856279.51         | -87227680.39         |
| 39213      | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс                                      | 6940279.00           | 6940279.00           |
| 39214      | Бусад үндсэн хөрөнгө  | 333698235.00         | 168673473.00         |
| 39215      | Хуримтлагдсан элэгдэл   | -51970156.11         | -28031032.74         |
| 39217      | Ном   | 26246285.50          | 27616685.50          |
| 393        | <b>Биет бус хөрөнгө</b>   | <b>942500.12</b>     | <b>71338572.20</b>   |
| 39301      | Програм хангамж   | 550000.00            | 550000.00            |
| 39302      | Хуримтлагдсан элэгдэл   | -250000.00           | -250000.00           |
| 39303      | Бусад биет бус хөрөнгө  | 1340000.00           | 72146072.00          |
| 39304      | Хуримтлагдсан элэгдэл   | -697499.88           | -1107499.80          |
| 3          | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>                                    | <b>3790725691.25</b> | <b>7401068397.21</b> |
| 4          | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>   | <b>22959204.41</b>   | <b>6046125.21</b>    |
| 41         | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | <b>22959204.41</b>   | <b>6046125.21</b>    |
| 413        | <b>Өглөг</b>  | <b>22959204.41</b>   | <b>6046125.21</b>    |
| 41310      | Ажилчидтай холбогдсон өглөг   |                      | 24030.00             |
